

АУДИТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТАЙЛАН

Огноо 2019.01.31

Хараат бус аудиторын  
тайлан

Дүгнэлт

Бид Аудитын тухай хуулийн 9.1.1-д заасны дагуу “Монинжбар” ХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан буюу Санхүүгийн байдлын тайлан, Орлогын дэлгэрэнгүй тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан болон тайлангийн тодруулгүудаас бүрдсэн Санхүүгийн тайланд аудит хийллээ.

Бидний үзэж байгаагаар “Монинжбар” ХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31- ний өдрөөр тасалбар болгон бэлгтэсэн санхүүгийн тайлангууд нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС), Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу материаллаг алдаа, зөрчилгүй илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн. АОУС-д заасан аудиторын хүлээх үүрэг, хариуцлагыг “Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг, хариуцлага” гэсэн хэсэгт тусгаж харуулав. Бид аудитын ажилд хамааралтай хараат бус байдлын болон ёс зүйн шаардлагуудыг бүрэн бислүүлж ажилласан. Бидний олж авсан баримт нотолгоонууд дээрх дүгнэлтийг гаргахад хангалттай, тохиромжтой гэж үзэж байна.

**Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага**

Санхүүгийн тайлангаа СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан заавар журмын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох стандарт, хуульд нийцүүлэн боловсруулан, тогтмол мөрдөж ажиллах нь байгууллагын удирдлагын үүрэг болно.

Мөн түүнчлэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангах, хөрөнгийг янз бүрийн залыт ажиллагаалд өртүүлэхгүй байхаар дотоод хяналтын системийг бий болгох, байгууллагын үйл ажиллагааны болон нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурь, зарчмыг хангаж ажиллах нь байгууллагын удирдлагын хариуцлага юм.

## Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлэх үүрэг, хариуцлага

Аудиторын гол зорилго нь үйлчлүүлэгчийн санхүүгийн тайлангууд нь алдаа эсвэл заллангийн улмаас материаллаг буруу илэрхийллээс ангид эсэхэд дүгнэлт огөхөд оршино. Тодорхой дүгнэлтэд хүрэхийн тулд АОУС-д нийцүүлэн боловсруулсан горимын дагуу шалгалт хийж, хангалитай, тохиромжтой баримт нотолгоо цуглуулах нь аудиторын үүрэг юм.

Аудитын горимуудыг батлагдсан төлөвлөгөөний дагуу аудитор өөрийн шийдлээр сонгох ба ирүүлсэн алдаа, зөрчил нь материаллаг буюу байгууллагын удирдлагага болон хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх эсэхэд дүн шинжилгээ хийж, түүнд тохирсон дүгнэлт огно.

Аудитын шалгалтаар байнга алдаа зөрчил илрэх ёстой гэсэн ойлголт байж болохгүй бөгөөд бидний илрүүлсэн алдаа, зөрчил материаллаг бус бол түүнийг арилгуулах талаар тодорхой зөвлөгөө өгч ажиллана.

Цаасан болон цахим хэлбэрээр бэлгүүсэн аудитын ажлын баримтууд нь тус компанийн өмч бөгөөд аудиторын тайлан, зөвлөмжийн хамт 10 жил хадгална.



Х.БАЯНБАЙ